

БАТЛАВ:ДЦС-4 ТӨХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

“ДЦС-4” ТӨХК

Огноо: **2020.06.30**

**РАЦ, ТҮҮНИЙ СЭЛБЭГ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/
гэрээний дугаар:** **ХХА-2020/83**

“ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА”

“ДЦС-4” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Рац, түүний сэлбэг материал нийлүүлэх тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг 2020 оны 07-р сарын 07-ний өдрийн 10.00 цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээнэ.

2020 оны 07-р сарын 07-ний өдрийн 10.30-д цахим системээр нээнэ. Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно

ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө
Утас:70181309, 7017-1357

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан сүүлийн нэг жил компаниййн гэрчилгээний хуулбар
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТОӨЗ-НЫ-ХОЛБОГДОХ ЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|--|
| ТОӨЗ 1.1 | <ul style="list-style-type: none"> - Сүүлийн [нэг] жилийн санхүүгийн тайлан болон /аудит шаардлагагтай/; - Компаний гэрчилгээний хуулбар хувь - Техникийн тодорхойлолт хангасан байх - Татварын тодорхойлолт |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: “ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс</p> <p>Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Захиргааны байр 3-р давхар 310,312 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 07-р сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер нээлт хийх газар хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: “ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс</p> <p>Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Захиргааны байр 3-р давхар 310,312 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 07-р сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p> |
| ТОӨЗ 6.2 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ХХА-2020/83 дугаартай Рац, түүний сэлбэг материал нийлүүлэх |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Рац, түүний сэлбэг материал

| № | Барааны нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|----------|--------------------------------|--------------------|-------------------|
| 1 | чадлын ёсгөгч-инжектор RoE-164 | ширхэг | 5 |
| 2 | гаралтын модуль | ширхэг | 4 |
| 3 | гранитур | ширхэг | 4 |
| 4 | тэжээлийн блок 13,8В 10А | ширхэг | 3 |
| 5 | эх хавтан | ширхэг | 2 |
| 6 | антенн 330-440MHz | ширхэг | 20 |
| 7 | батарей | ширхэг | 6 |
| 8 | батарей | ширхэг | 2 |
| 9 | батарей | ширхэг | 30 |
| 10 | гаргалтын чадлын модуль | ширхэг | 16 |
| 11 | корпус | ширхэг | 2 |
| 12 | рац Motorola GP328.ptx-760 | ширхэг | 2 |

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---------------------------------------|--------------|------------|-------------|--|---|--------------------------|--------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Рац, түүний сэлбэг материал нийлүүлэх | | | ширхэг | ДЦС-4 ТӨХК-ийн агуулах | 7 хоног | 30 хоног | |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ № СХА-07

**Бараа материалын нэр: Богино долгионы гар болон
суурин станцуудын сэлбэг**

Ерөнхий шаардлага:

| | Техникийн өгөгдөл | Техникийн үзүүлэлт | Нэмэлт шаардлага | Дүйцүүлэх нэршил |
|---|---|---|--|--|
| 1 | Моторола PTX 760, GP-328 загварын станцын гаралтын модуль | 5W, 300MHz–500MHz | модулийг сольж засварлана | M1517T1 |
| 2 | антенн | коннекторын төрөл SMA-MX өсгөлт 0.5dB Ажиллах давтамж 330-400 MHz | Антенны урт 16см-с багагүй | Моторола GP-328, PTX-760 гар станцуудын антенн |
| 3 | батарей | li ion 7,5V 1500mAh | Цэнэг барих хугацаа 15цаг буюу түүнээс дээш Ажиллах температур -30 аас 60 градус Цэнэг авах хугацаа 2 цагаас ихгүй | HNN9013 |
| 4 | Моторола GM-328 загварын станцын гаралтын модуль | Гаралтын чадал 25Вт буюу түүнээс дээш Ажиллах давтамж 150-500 MHz | модулийг сольж засварлана | MRF1535N |
| 5 | гранитур | контактын тоо /птт кноп/1 сая | | PMMN4007A |
| 6 | Моторола GM-338 суурин станцын эх хавтан /board/ | Гаралтын чадал 25Вт буюу түүнээс дээш Ажиллах давтамж 330-400 MHz мэдрэх чадвар (12dBSINAD 0.25uV Typical | | |

Богино долгионы гар радио станцын техникийн шаардлага.

Зорилго: Станцын үйлдвэрлэл, технологийн процессын шуурхай ажиллагааг найдвартай хурдан гүйцэтгэх холбооны хэрэгсэл юм.

Нэвтрүүлэгчийн ажиллах үелзлэлийн хуваарь: 330-400MHz

Гаралтын чадал: 4W

Суваг хоорондын зайд: 12.5 kHz

Үезлэл тогтвортойлжилт (-30 -- +60 градуст): 0.5/1.5 ppm

ФМ модуляцийн сигнал шуугианы харьцаа: -40dB

Модуляцийн төрөл (FCC): 12.5kHz/ 11KOF3E

Хүлээн авагчийн ажиллах үелзлэлийн хуваарь: 330-400MHz

Хүлээн авагчийн мэдрэх чадвар -118 dB

Интермодуляци: 65-70dB

Хажуугийн сувгийн нөлөө аналог-д: 60dB@12.5kHz

Шуугиан, паразит модуляци хаах чадвар: 70dB

Үйлдвэрийн болон орчны статик шуугианаас харилцан нөлөөлдөггүй, хамгаалалттай байх

ALT шалгуурыг хангасан байна.

Чанга яригчийн чадал: 500mW

Дууны сигналын гажуудал: 3%

Ажиллах сувгийн тоо : 8 ба түүнээс дээш

Ажиллах температур: -30 ----+60°C

Хүйтэн нөхцөлд олон цагаар гадаа ажиллах боломжтой, халуун хүйтэнд тэсвэртэй байх,

Батарейн хүчдэл: 7.5V

Батарейн төрөл, багтаамж: Lithium-Ion 2200 mAh

Цэнэг барих хугацаа 15 цагаас багагүй

Цэнэглэгч: цэнэглэх хугацаа 2 цаг

Жин: <500 гр

Хангасан байх ёстой стандартууд:

- Доргилт, даралт, радиац MIL-STD 810-c,D&E

- Тоосжилт, чийгшилтийн MIL-STD 810-c,D&E

- Ус борооны хамгаалалт бүхий IP 54 стандарт хангасан байх.

Дугаар (caller ID): станц болгон дугаар илрүүлэх

Дагалдах иж бүрдэлд. Станц, Батерей, цэнэглэгч, антенн бүсний хавчаар

Өгөгдсөн давтамж дээр программчлал болон харилцан нөлөөллөөс хамгаалах бүхий л тохиргоо, туршилтын ажлыг хариуцаж хийнэ

Баталгаат хугацаа 2 жил

ДЦС-4 ТӨХК-ний Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг танаа

- Бид,дор дурдсан барааг(.....) төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ |
|--------------------|--------------|------------------------------|------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Тендерийн нийт үнэ | | | | |

Баталгаат хугацаа:12 сар

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [нэг] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> <p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p> <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹</p> | <p>1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]</p> <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</p> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0,1] Алдангийн нийт дүн: гэрээний үнийн дүнгийн [гучин] хувь</p> |
|--|--|

¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-4” ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 он..... сарын.....ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь цахилгаан хөдөлгүүрийг 2020 оны ... дугаар сарын ...-наас 2020 оны... дугаар сарын-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

- Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Менежер

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДЦС-4” ТӨХК Худалдан аваа Хаяг:.....Утас/факсын дугаар:
ажиллагааны хэлтэс

Утас/факс 70181309, 70181357

Банк: Хаан банк 5038008126

Голомт банк 1202038052

БАНК:

ДАНС: